

Эрдэмтэн Р.Отгонбаатарын эрдмийн ажил

Дашнямын МӨНХ-ОТГОН*
Монгол Улс, Улаанбаатар,
Шинжлэх ухааны академийн
Хэл зохиолын хүрээлэнгийн
Төвөд судлалын салбар

Received: Aug 08, 2025 | **Revised:** Nov 05, 2025 | **Accepted:** Dec 04, 2025

Хураангуй: Ардын багш Дагвын Чойжилсүрэн, ардын уран зохиолч, академич Цэндийн Дамдинсүрэн нарын шадар ойрын шавь Р.Отгонбаатар 1978 онд Монгол Улсын их сургуулийг монгол хэл уран зохиолын багш мэргэжилтнээр төгсөөд сургуульдаа багшаар үлдэж, төд удалгүй Хэл зохиолын хүрээлэнд эрдэм шинжилгээний ажилтнаар ажилласаар өндөр насны тэтгэвэртээ гарчээ. Хүрээлэнгийнхний маань дотночлон бас хүндэтгэн авгайлдгаар “Баавай” буюу “Отгон баавай” гуайн эрдэм шинжилгээний ажлын туршлага, арга барил, ололт амжилтын талаар энэхүү өгүүлэлд дурдах юм.

Эрдэмтэн Р.Отгонбаатар идэр залуугаасаа эрдэм номын ажилд шамдаж олон ном бүтээл туурвиж, эрдэм шинжилгээний өгүүлэл илтгэл ч арвин ихийг бичиж хэвлүүлэн хэлэлцүүлсэн юм. Түүний бүтээлүүдээс ажиглахад дийлэнх хэсэг нь монгол төвөд эх бичиг сурвалж судалгааны холбоотой зүйлс бий.

Түлхүүр үг: Модон бар, монгол төвөд ном хэвлэл, эртний бар хэвлэлийн тойм, гарчиг

The Research Achievements of Dr. R. Otgonbaatar

MUNKH-OTGON Dashnyam
The Sector of the Tibetan Studies,
Institute of Language and Literature,
Mongolian Academy of Sciences,
Ulaanbaatar, Mongolia

Abstract: R. Otgonbaatar, an eminent scholar and close disciple of People’s Teacher D. Chojilsuren and National Writer, Academician Ts. Damdinsuren, graduated from the National University of Mongolia in 1978 with a degree in Mongolian Language and Literature Education. After graduation, he remained at the university as a lecturer and later joined the Institute of Language and Literature as a research fellow, where he worked until his retirement.

* © Д.Мөнх-Отгон 2025
Email: munkhotgond@mas.ac.mn

Affectionately known among his colleagues as “Baavai” or “Otgon Baavai,” he is remembered with deep respect and fondness.

This article highlights Dr. Otgonbaatar’s research experience, scholarly methods, and academic achievements. From a young age, he devoted himself to research, publishing numerous books, papers, and conference presentations. His works predominantly focus on studies related to Mongolian-Tibetan manuscripts and source materials.

Key words: *Woodblock printing, Mongolian-Tibetan publications, overview of early printing, catalogues*

1. Удиртгал

Р.Отгонбаатар 1980-аад оны дунд үеэс эхлэн “Соёмбо үсэг сүлд тэмдгийн холбоо” (1986), “О тибетском и монгольском каталогих ксилографов, изданных в конце XIXв.” (1989), “Халх модон барын монгол ном хэвлэл” (1992), “Один из гарчаков Д.Галсажамбы” (1995) зэрэг эрдэм шинжилгээний илтгэл, өгүүллүүдээ хэлэлцүүлж хэвлүүлж эхэлсэн байна. Эдгээр нь тухайн үедээ монголчуудын хэдэн зуун жилийн туршид зохион хэрэглэж ирсэн олон зүйл үсэг бичиг болоод тэдгээрийг хэвлэж байсан уламжлалт арга болох бар хэвлэлийн түүхэн тойм, төлөв байдлын талаарх асуудлыг хөндөж эхэлснээрээ судлаачдын анхаарлыг татаж эхэлсэн юм.

Тэрээр оюутан ахуйгаасаа ардын багш Дагвын Чойжилсүрэн (1911-1993), академич Цэндийн Дамдинсүрэн (1907-1986) зэрэг эрдэмтэн багш нарт шавилсны зэрэгцээ тэр үедээ Хүрээний номтой шүнтэй өвгөчүүлээс олон сайхан хууч яриа, аман домог гэх мэт зүйлсийг сонсож мэдсэн нь хожмын судалгаа шинжилгээнд минь асар их хувь нэмэр үзүүлсэн гэж хуучилсан билээ.

Түүний олон жилийн турш бичиж нийтлүүлсэн өгүүлэл, ном бүтээлүүдээс ажиглахад дийлэнх хэсэг нь монгол төвөд эх бичиг сурвалж судалгааны холбоотой зүйлс байна. Тэр дундаа ховор чухаг, эрхэм нандин дурсгал бичгүүдийг онцгойлон анхаарч, түүнийгээ судалгаа шинжилгээний эргэлтэд оруулахыг эрмэлзэж байсан нь илт харагдана. Түүнчлэн олон зүйл үсэг бичгийн дурсгал, үйрмэг үлтэрхий дээр ч мөн уйгагүй ажилласан манай ахмад эрдэмтдийн нэг мөн.

2. Судалгааны арга, эх хэрэглэгдэхүүн

Энэхүү өгүүлэлд эрдэмтэн Р.Отгонбаатарын насан турхруу бичиж нийтлүүлсэн, хэвлэж түгээсэн эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэл, ном бүтээлийг нь нэгтгэн бүртгэх, задлан шинжлэх, ангилан хуваах, дүгнэх гэх мэт аргуудыг ашигласан бөгөөд эрдэмтний бичиж туурвисан ном бүтээлийг судалгааны эх хэрэглэгдэхүүнээр хэрэглэсэн болно.

3. Судалгааны хэсэг

Р.Отгонбаатар багшийн эрдэм шинжилгээний гол чухал бүтээлүүдийг нь дараах хэдэн чиглэлд хуваан хэлэлцэж болно.

Нэг. Бар хэвлэлийн судалгаа. Үүнд нүүдэлч монголчуудын олон зуун жилийн түүх соёлын өв болох эрт цагийн ном хэвлэлийн төлөв байдал, түүхэн тойм, сүм хийдийн бархны уламжлалт гарчигт тулгуурласан судалгаа зонхилж байна. Жишээлбэл: “Монгол

модон барын номын эх гарчиг” (1998) хэмээх Япон улсын Токио хотноо хэвлүүлсэн бүтээлдээ халх, өвөрлөгч, буриад нутгийн модон барын монгол номын гарчгийн сонгомол жишээ болох хорь орчим гарчгийг сонгон оруулж, эх бичгийн галиг хийж, гэрэл зургийг хавсаргасан байна. Тэргүүн хэсэгтээ Халх монголын Арвайхээрийн хүрээний бандида лам Цэвэлванчигдоржийн бүтээн туурвисан номын гарчиг, дэд хэсэгтээ Өвөр монголын Урадын мэргэн гэгээн Лувсандамбийжалцаны зохион найруулсан номын гарчиг, гутгаар хэсэгтээ Буриад монголын Цүүгэл дацангийн ширээт Агваанлуvsангалсанжамбын орчуулан соёрхсон номын гарчиг хэмээн дотор нь гурван том бүлэгт хуваан ангилж бичсэн юм. Энэ нь нийт монгол туургатны ном хэвлэлийг төлөөлж чадахуйц гурван нутгийн гурван эрдэмтэн ламын бүтээсэн олон зүйл гарчгийн монгол төвөд баруудыг олж тулган нягталж хүснэглэн нэгэн дор багтаасан эрдэм шинжилгээний чухал ач холбогдолтой бүтээл болсон билээ.

Бас нутаг нутгийн хийдийн монгол төвөд бар хэвлэлийн тойм хийгээд зарим нэг хувь хүний бүтээсэн чухаг ховор эх бичгийн дурсгал, гарчгуудыг цуврал маягаар нийтлүүлсэн нь олон бий. Тухайлбал: “Халх модон барын монгол ном хэвлэлийн тойм” (1992), “О тибетском и монгольском каталогих ксилографов, изданных в конце XIXв. (1989), “Один из гарчаков Д.Галсажамбы” (1995: 28-33), “Заяын хүрээний бар хэвлэлээс” (2013: 162-169), “Чоймзод ламын хийдийн модон барын тойм” (2015: 144-175), “Сайн ноён хан аймгийн Хошуу хүрээний бар хэвлэлийн тойм” (2016: 42-66), “Буриадын Эгэтийн дацангийн төвд бар хэвлэлийн тойм” (2017: 86-104), “Ламын гэгээний хийдийн бар хэвлэлийн тойм” (2018: 44-91), “Хутагт ламын хийдийн бар хэвлэлийн тоймоос” (2020: 25-36), “Хувь хүний бүтээсэн модон барын номын хэвүүд хийгээд нэгэн төвөд барын гарчиг” (2021: 86-97), “Бээжингийн уламжлалт хэвлэлийн нэгэн бичмэл гарчиг” (2022: 140-149), “Өвөр монголын монгол бар хэвлэлийн тойм” (2023:) зэрэг эрдэм шинжилгээний өгүүллээс нь харж болно. Эдгээр өгүүллийнхээ дийлэнхэд нь монгол төвөд бичмэл дармал гарчиг, эш баримт зэргийг давхар тодруулан лавшруулж мэдээлсэн нь олонтоо. Бүр тодруулбал “Заяын хүрээний бар хэвлэлээс” өгүүлэлдээ: Арвайхээрийн хүрээнд барласан уг хүрээний барын гарчиг, Монгол Улсын Үндэсний төв архив дахь нэгэн жижиг бичмэл гарчиг зэргийг харгуулан тулгаж, гэрэл зургийг хавсаргасны хажуугаар мөн хүрээнд хэвлэсэн барын гарчигт буй нэгэн номын жишээг үзүүлсэн байна. “Бас гарчиг ганц хуудас боловч гайхамшигтай дурсгал гэдгийг хүндэтгэн үзэж дээдлэх ёстой. Учир нь алга дарам цаасны ар өвөрт арав тавхан ном биш хорь гучин том жижиг номыг уламжлалт модон барын аргаар хэвлэсний хөдөлшгүй баримт мөн. Тэгэхдээ түм шахам нүүр хуудсыг дармаллаж хэвлэж байсны маргашгүй баримт энэхүү нэгэн хуудас болно” (Отгонбаатар, 2013: 164) хэмээн чухал дүгнэлтийг хэлсэн юм. “Буриадын Эгэтийн дацангийн төвд бар хэвлэлийн тойм” өгүүлэлдээ дармал бичмэл хоёр ч төвөд гарчгийг ашиглан уг дацангийн бар хэвлэлийн тоймыг дурдан ахиулсан судалгааг хийсэн байна. Түүний бичиж нийтлүүлсэн дээрх эрдэм шинжилгээ судалгааны өгүүлүүдийн үр дүн нь нийт монгол туургатны модон барын аргаар монгол төвөд ном судар барлан хэвлэж байсны тойм төлөвийг эрдэм шинжилгээний эш баримт, сурвалж хэрэглэгдэхүүнд тулгуурлан нэгтгэн гаргаж ирсэн чухал судалгаа болжээ.

Хоёр. Нэн эртний модон барын ном судрын тасархайг таньж тодруулсан судалгаа. Тэрээр эх бичиг, сурвалж судлал, ном хэвлэлийн түүхэн төлөв тоймыг тодруулан судалсан ажлын дүнд хэд хэдэн ховор чухаг эртний ном судрын үйрмэг

үлтэрхийг таньж тодолсон судалгааг хийжээ. Үүнд: “Хачин гайхамшигт дурсгал Хар хотоос илэрлээ” (2013: 41-44), “Монголоор сударчилж хэвлэсэн дөрвөлжин үсгийн Субашидын шинэ хуудас” (2013: 29-36), “Зурагт монгол судрын эртний хэвлэлийн хэсэг” (2020: 14-19), “Эртний зурагт модон барын монгол номын хоёр дурсгал” (2020: 19-25), “Найман гэгээн номын эртний монгол хэвлэлийн тасархай” (2020: 30-33), “Мэдэгдэхүүнийг бэлгэтээе гийгүүлэгч номын эртний монгол бичгийн хэвлэл” (2024: 59-65) зэрэг эрдэм шинжилгээний чухал үнэ цэнтэй өгүүллүүдийг бичиж хэвлүүлсэн байна. “Хачин гайхамшигт дурсгал Хар хотоос илэрлээ”, “Монголоор сударчилж хэвлэсэн дөрвөлжин үсгийн Субашидын шинэ хуудас” зэрэг өгүүлэлдээ тулгуурлан “Дөрвөлжин үсгийн тухай дөрвөн зүйл” (2014) хэмээх нэг сэдэвт бүтээлээ бичиж хэвлүүлэв. Уг ном нь нэгэн дармал нүүрийн дундаас дээд хэсгийн тасархай арав гаранхан үг үлдсэнийг ямар ном болохыг тодруулж, бас нэг тодорхой үгтэй тамтархай аль номын хэддүгээр бадаг шүлэгтэй хуудсын хэсэг мөнийг илчлэн баталж, тэдгээрийн цаг үед хамаарах дурсгалд цэг тэмдгийг хэрхэн ямаршуу хэлбэртэй бичиж барласан хийгээд түүнээс уламжлан хожуу үеийнхэн уг цэг тэмдэг зэргийг яаж өргөжүүлэн хэрэглэсэн байдлыг эх бичигт нь дулдуйдан тодруулж уугуул үсгээ дөрвөлжлөн эвхмэллэснийг жишээ болгон үзүүлжээ. Уг бүтээл нь анх удаа монгол хүн дөрвөлжин үсгийн томоохон номыг эрт цагт хэвлэснийг таньж тодруулсан чухаг үнэ цэнтэй судалгааны ажил болсныг тэмдэглэх хэрэгтэй. Энэ нь дөрвөлжин үсгийн чухал дурсгалыг цоо шинээр тодруулсан төдийгүй түүний эх төвөд зохиолынх нь холбогдох хэсгийг тулган шалгахдаа гар бичмэл болоод модон барын зөрөөг хүртэл нягталсан нь төвөд эх бичиг судлалын хувьд ч Монгол улсын эрдэм шинжилгээний хүмүүс төвөд эх сурвалжийн баялаг өвтэй болохыг давхар нотлон харуулсан гэж болно. Ахмад эрдэмтэн өөрөө ч энэ тухайгаа: “Малтлагаар илэрсэн маш эртний дөрвөлжин үсгийн өчүүхэн боловч дурсгалууд нь өдөр бүр олодох өөдөс биш, үзсэн бүхэн унших тасархай бус билээ.” (Отгонбаатар, 2014: 11) гэж бичсэн нь үнэний хувьтай. Бас “... одоогоор олдсон монгол хэлээр дөрвөлжин үсгээр барласан хамгийн том номын тасархайг үг утгаар нь хоёр талаас нь хашиж шахан хайж тодруулсан хийгээд Субашидын сударчилсан хэвлэлийн шинэ хуудас хэмээн нэрийдсэн зүйл маань үсгийн өчүүхэн өөдөс хэсгээр гул барин мөрдөж мөшгөөд тодруулсан хэрэг юм” (Отгонбаатар, 2014: 11) хэмээн эл бүтээлээ даруухан бөгөөд далайцтай дүгнэсэн ажээ.

Түүнчлэн дээр дурдсан “Зурагт монгол судрын эртний хэвлэлийн хэсэг”, “Эртний зурагт модон барын монгол номын хоёр дурсгал” зэрэг өгүүлэлдээ дулдуйдаж “Монгол модон барын зурагт ном хэвлэл” (2021) бүтээлийг хэвлүүлэв. Эл бүтээлдээ зурагтай дармалласан цагаан толгой, Дара эх, Жанжаа хутагтын төрөл үеийн залбирал, Там бирдийн ном, Молон тойны намтар зэрэг олон зүйл ном судрын өөр өөр хэвлэлийг багтаан гэрэл зургийг чанарын өндөр түвшинд хавсаргасан нь онц ач холбогдолтой. Мөн уул бүтээлдээ монголын зурагт ном хэвлэлийн түүхэн төлөв байдлыг бүхэлд нь тоймлосон дэлгэрэнгүй эрдэм шинжилгээний удиртгал бичсэн бөгөөд энэ нь зурагт ном хэвлэлийн түүхэн баримтыг хэдэн зуун жилээр урагшлуулан тодруулсан онцгой ажил болсон гэдгийг тэмдэглэвээс зохино.

“Эртний зурагт модон барын монгол номын хоёр дурсгал” өгүүлэлдээ Япон болон Хятад улсад хэвлэсэн хоёр ном дээр нэгэн зургийг сэргээн хэвлэсэн нь зөрөөтэй

байсныг анзаарч гүнзгийрүүлэн тэр цагийн монгол уйгар бусад зурагтай судар номуудын хэсэгтэй харьцуулан судалж бичсэн буй.

Гурав. Олон зүйл үсэг бичгийн дурсгал, цагаан толгой, хэл зүйн бичгүүдийн судалгаа. Тэрээр өөрийн баялаг цуглуулгын зарим хэсэгтээ тулгуурлан эрдэмтэн А.Д.Цендинагийн хамт “Монгол үсэг бичгийн дээж” хэмээх бүтээлээ 2014 онд монгол орос хоёр хэлээр хэвлүүлэв. “Монгол үсэг бичгийн дээж” номд монгол үсэг бичгийн ховор нандин дээж дурсгалаас гадна Монгол улсын нутагт сүүлийн хэдэн зуун жилийн турш ноёлог хэрэглэж байсан төвөд хэл бичиг, түүнийг сурч байсан монголчуудын өв ухааны дээж, түүнчлэн самгарьд, төвөд үсгийг галиглах ёс, түүгээр ном судар бичиж байсан жишээ төдийгүй манж, хятад үг үсэг бичгийг буулгах ёс болон тод, соёмбо, хэвтээ дөрвөлжин үсэг зэрэг олон зүйл үсэг хэрэглэсний зарим дурсгал, тэдгээр хэл бичиг, бүр орос хэлийг ч сурч байсан сонин баримт зохих хэмжээгээр туссан байна. Иймд энэ ном нь монгол хэл бичиг төдийгүй монголчуудын хэрэглэж байсан үсэг бичгийн олон эх сурвалжуудыг нэгтгэж, шинээр судалгааны эргэлтэд хүргэсэн аж. Мөн эх бичиг сурвалж судлал, монгол болон дорно дахины өв соёлын судлалын чиглэлээр ажилладаг эрдэмтэн судлаач, оюутан сурагчдад гарын авлага, сурах бичиг болох практик ач холбогдолтой байна. Номын агуулга бүтцийн хувьд зургаан бүлэгтэй. Үүнд: 1. Монгол бичиг сурах монгол номын аймаг (монгол бичгээ сурч байсан уламжлалт гол гол цагаан толгой хэл зүйн бичгүүд), 2. Монгол бичиг сурах төвөд номын аймаг (монгол хэл бичгийг монгол бичгээрээ сурахаас гадна төвөд хэл бичгийг дамжуулан сурч байсан найман зүйл бичмэл, дармал сурах бичиг хэл зүйн номууд), 3. Төвөд үсэг сурах монголчуудын номын аймаг (төвөд үсэг бичиг сурдаг монголчуудын уламжлалт аргын эх хэрэглэгдэхүүн 10 зүйл), 4. Олон хэл бичиг тэмдэглэх монгол номын аймаг (олон хэл бичгийг тэмдэглэх монгол үсгийн дурсгалууд), 5. Төвөд үсгээр үгчилсэн монгол бичгийн аймаг (төвөд үсгээр үгчлэн бичиж монгол хэл бичгээ орлуулдаг уламжлал томхон арга байсны зүйл бүрийн сонин жишээ), 6. Олон зүйл үсгээр бичсэн монгол номын аймаг (монгол төвөд бичгээс өөр үсгээр монгол хэлийг тэмдэглэсэн жишээ) гэсэн бүлгүүдэд хуваан дэлгэрэнгүй тайлбар өгүүлэл дагалдуулан бичсэн нь ихэд сайшаалтай болжээ. Энэ ажил бол урьд өмнө монгол хэл бичгийн судалгаанд огт өртөөгүй шахам ховор сонин эх бичгүүдийг анх удаа эрдэм шинжилгээний олон нийтэд хүргэснээрээ онцлог давуу талтай. Манай улсын энэ салбарын эрдэмтэн судлаачдын ажлыг шинэ шатанд гаргасан монгол хэл бичгийн судлалын түүхэнд онцгой байр суурь эзлэх бүтээл болсон байна. Хамтран зохиогч орчуулагч нь ч чадвартай эрдэмтэн учир их Орос улсын Дорно дахины эх бичиг судлалын уламжлалын дагуу чанар чансаатай “Наука” гэдэг хэвлэлийн газрыг дамжуулан хоёр хэлээр зэрэг нийтэлсэн нь олон газрын эрдэм номын хүмүүс үзэж хэрэглэхэд бахархууштай ном болжээ. Тийм ч учраас тухайн жилийнхээ Оросын Шинжлэх ухааны академийн Дорно дахины судлалын хүрээлэнгийн шилдэг бүтээлээр шалгарч байжээ.

Дөрөв. Өөрийн нямбай судар номын цуглуулга хийгээд бичгийн хэрэгсэл, эд өлөг зэрэг зүйл дээр тулгуурлан олон ном бүтээл туурвиж байна. Үүнд: “Итгэл номын монгол соёл уламжлал” (2017) хэмээх номыг хэвлүүлэв. Итгэл хэмээх хар шар сүсэгтэн олны дунд алдартай жижиг боловч жинтэй судрыг сонгон авч өөрийн цуглуулга дээр дулдуйдсан шинжтэй, чухал зарим нэг эхийг хүрээлэнгийн сан хөмрөгөөс ашиглан оруулсан бөгөөд олон үсгээр олон зүйлээр бичиж барласан 30 орчим эхийг анх удаа

нэгэн доор хэвлэж олон түмэнд хүргэжээ. Бас “Монголчуудын ном судар бүтээдэг эд өлөг” (2020) жижиг товхимлыг бэлтгэн хэвлэв. Энэ нь бидний үеийнхэн бараг мэдэхээ байсан, огт үзэж хараагүй бичгийн хэрэгслүүдийг биетэй бодтойгоор нь цуглуулаад, түүнийгээ юунд яаж хэрэглэдгийг товч тодорхой бичиж үлдээсэн нь угсаатны зүйн шилдэг тэмдэглэл болж үлдлээ гэж дүгнэн хэлж болно.

Тав. Ховор чухаг, нэн сонин дурсгалд тулгуурласан чамбай өгүүлүүд олныг бичиж нийтлүүлжээ. Тухайлбал: “Д.Нацагдоржийн номын тэмдгийн тухай” (1986), “Сайнчунгаагийн гарын тэмдгийн тухай” (2024) гэх мэт хоорондоо хорь гучин жилийн зайтай бичсэн өгүүлэл нь Монголд болон Өвөр монголд алдартай хоёр зохиолчийн ном бүтээлдээ ашигладаг байсан гарын тэмдгийг анх тайлж тайлбарлан нийтэлсэн хэрэг мөн. Бас Ноён хутагт Равжаагийн зохиол бүтээлийн талаар “Хутагт найрагчийн хурц уянгын нэгэн” (1992), “Равжаагийн монгол төвөд хэлээр бичсэн хошоод шүлгийн тухай” (2019), “Ноён хутагтын зохиолын нэг үгийг зөв буулгах тухайд” (2024) зэрэг урьд өмнө судалгааны олон нийтэд мэдэгдээгүй шинэ эх бичгийг олж нийтэлсэн, үг үсгийг засаж залруулж нягталсан чухал өгүүлүүдийг бичсэн билээ. Түүнчлэн “Мэгзэмийн холбоотой монголчуудын бүтээсэн хоёр жижиг зохиолын тухай” (2011), “Шагж гуайн бүтээл Сахиусан Дара эх” (2013), “Ганжуурын зарим боть номыг монгол хүний хураангуйлсан жишээ” (2017), “Сайчунга зохиолчийн өвөрмөц сонирхолтой шүлгийн өвөөс” (2024), “Бурхан багшийн намтарт холбогдох үйснээ бичсэн шүлгийн эхлэл” (2024) гэх мэт олон өгүүлийг нь дурдаж болно.

Зургаа. Багш нарынхаа тухай болон ахмад дээдсийн тухай дурсамж, дурдатгал олныг бичиж нийтлүүлсэн нь хойч үеийнхэнд чухал гарын авлага болох юм. “Судрын санг эрхлэгч сүүл үеийн гурван өтгөс” (2014), “Эрдэнэпэл хамбын эрдэм номын үйлс” (2017), “Багшийн зарим шүлэг зохиолоо бичсэн тухайд” (2019), “Данзан-Осор гуайтай цөөн уулзсанаа далимдуулж хэлхсэн хэдэн үг” (2020), “Х.Гаадан багшийн төвөд хэл бичих заасан онцлогоос” (2023) зэрэг олон сайхан дурсамж, дурдатгалыг нийтлүүлсэн байна.

Долоо. Гол багшийнхаа буюу Ц.Дамдинсүрэн багшийнхаа бүтээлүүдийг хэвлэн нийтлэхэд нэлээд хүч хөдөлмөрөө зориулсан байна. Багшийнхаа тухай “Тэрэгний тухай шүлэг” (1989), “Чингисийн төрсний 800 жилийн ойн хурал дээр хэлсэн үг” (1990), “Захиргаадуулсан хэргийн зарим баримт” (1990), “Хилстүүлсэн хэргийн хэдэн баримт” (1990), “Шинэ үеийн ууган түүвэр зохиол” (1994), “Наран улстай дипломат харилцаа тогтоох Дамдинсүрэнгийн санал” (2002) гэх мэт баримт сэлтийг анх хэвлэн нийтэлж байсан байна. Мөн “Намтрын хуудсаас” (1991), “Жангар” (1998), “Монголын нууц товчоо”, “Монгол Гэсэрийн тууж”, “Монгол Жангарын тууль” (2008), “Морь шинжээч Жомбоо хүү” (2013) зэрэг ном бүтээлийг нь ахин эмхэтгэж хэвлүүлж байжээ. Мөн академич Ц.Дамдинсүрэн багшийнхаа мэндэлсний 110 жилийн ойд зориулан эрдэм шинжилгээний ном бүтээлийг нь эмхэтгэн цэгцэлж “Эрдэм шинжилгээний бүтээлийн чуулган”-аар 9 боть болгон 2017 онд хэвлүүлсэн бөгөөд “Ц.Дамдинсүрэнгийн гэр музейн монгол ном судрын бүртгэл”, “Ц.Дамдинсүрэнгийн гэр музейн төвд ном судрын бүртгэл”, “Ц.Дамдинсүрэнгийн ном судрын цуглуулгын тухай” бүтээлүүдийг 2018 онд эрдэмтний охин А.Д.Цендинагийн хамтаар эрхлэн хэвлүүлжээ. Түүнчлэн “Судар бичгийн сан” цувралаар “Түүхийн бичмэл эх”, “Монгол Алтангэрэл судар”, “Монгол Молон тойны судар” (2022) гурван боть, “Ц.Дамдинсүрэнгийн өдрийн тэмдэглэл” (2025)

зэргийг хэвлэн нийтлээд байна. Эдгээр нь бүхэлдээ эрдэмтэн багшийнхаа насан турш хийж бүтээсэн эрдэм судлалын энгүй их ажлыг олон түмэнд түгээн таниулах, сурвалжлан сурталчлах номын их суварга босгосон гэж хэлж болох билээ.

4. Дүгнэлт

Эрдэмтэн Р.Отгонбаатар олон жилийн турш эртний ном судар, тэдгээрийн тасархай тамтархай, үйрмэг үлтэрхий болон бар хэвлэл, эх бичиг, сурвалж судлал, үсэг бичгийн шинжлэлээр голлон ажиллаж шинэ үеийн сэхээтэн залуус, эрдэмтэн судлаачдад шимтэн унших ширээний ном болох бүтээл олныг бичиж хэвлүүлсэн байна. Түүний бичиж нийтлүүлсэн эрдэм шинжилгээний ном бүтээл, судалгааны өгүүллүүдийн үр дүн нь нийт монгол туургатны модон барын аргаар монгол төвөд ном судар барлан хэвлэж байсны түүхэн тойм төлөв байдлыг эрдэм шинжилгээний эш баримт, сурвалж хэрэглэхүүнд тулгуурлан нэгтгэн гаргаж ирсэн чухал судалгаа болжээ.

Гагц үг үсэг төдий дурсгалыг ч өөд нь татаж соёлын том өв эртний ном хэвлэлийн үлгэр жишээ болгосон нь манай монголын ард түмний соёлын түүхийг тодруулахад юугаар ч сольшгүй, яаж ч магтаад баршгүй гавьяатай үйлс, уйгагүй хичээл зүтгэл, нөр их хөдөлмөр, мэдлэг бодлогын үр шим мөн.

Ном зүй:

- Отгонбаатар, Р.** (1998). *Монгол модон барын номын эх гарчиг*. Токио: [Otgonbaatar, R. *Mongol modon baryn nomyn ekh garchig* [Titles of Mongolian Woodblock Prints] Tokyo: 1998]
- Отгонбаатар, Р. Цендина, А.Д.** (2014). *Монгол үсэг бичгийн дээж* (Цагаан толгой, галиг зэрэг дурсгал. ХҮІ зууны эцсээс ХХ зууны эхэн үе). Образцы письменной традиции северной Монголии (Алфавиты, транскрипции, языки. Конец ХҮІ-начало ХХ в). М., 25 хх. Москва: Наука хэвлэлийн газар. [Otgonbaatar, R. & Tsendina, A.D. *Mongol üseg bichgiin deej (tsagaan tolgoi, galig zereg dursgal. XVI zuuny etssees XX zuuny ekhen üy)* [Samples of Mongolian Script Traditions] (*Alphabets, Transcriptions, Languages. Late 16th – Early 20th Century*). Moscow: Nauka Publishing House, 25 pp. 2014]
- Отгонбаатар, Р.** (2014). *Дөрвөлжин үсгийн тухай дөрвөн зүйл*. Улаанбаатар: [Otgonbaatar, R. *Dörvöljin üsгийн tukhai дөрвөн зүйл*. [Four Essays on the Square Script]. Ulaanbaatar: 2014]
- Отгонбаатар, Р.** (2017). *Итгэл номын монгол соёл уламжлал*. Улаанбаатар: [Otgonbaatar, R. *Itgel nomyn mongol soyol ulamjlal*. [Mongolian Culture and Traditions of Religious Texts] Ulaanbaatar: 2017]
- Отгонбаатар, Р. Цендина, А.Д, Билгүүдэй, Г.** (2018). *Ц.Дамдинсүрэнгийн гэр музейн монгол ном судрын бүртгэл*. Улаанбаатар: Соёмбо хэвлэлийн газар. [Otgonbaatar, R., Tsendina, A.D., & Bilguudei, G. *Ts.Damdinsürengiin ger muzein mongol nom sudryn бүртгэл*. [Catalogue of Mongolian Books and Scriptures in the Ts. Damdinsuren Memorial Museum] Ulaanbaatar: Soyombo printing. 2018]
- Отгонбаатар, Р. Цендина, А.Д.** (2018). *Ц.Дамдинсүрэнгийн ном судрын цуглуулгын тухай*. Улаанбаатар: Соёмбо хэвлэлийн газар. [Otgonbaatar, R. & Tsendina, A.D. *Ts.Damdinsürengiin nom sudryn tsugluulgyn tukhai*. [On the Collection of Mongolian Books and Scriptures of Ts. Damdinsuren] Ulaanbaatar: Soyomb printing. 2018]

- Отгонбаатар, Р.** (2020). *Монголчуудын ном судар бүтээдэг эд өлөг*. Улаанбаатар: /Танин мэдэхүйн цуврал-58/ [Otgonbaatar, R. *Mongolchuudyn nom sudar büteedeg ed ölog*. [Artifacts Used in the Creation of Mongolian Scriptures] Ulaanbaatar: Cognitive Series-58, 2020]
- Отгонбаатар, Р.** (2021). *Монгол зурагт модон барын ном хэвлэл*. Улаанбаатар: [Otgonbaatar, R. *Mongol zuragt modon baryn nom khevlel*. [Mongolian Illustrated Woodblock Prints] Ulaanbaatar: 2021]
- Отгонбаатар, Р.** (1990). *Д.Нацагдоржийн номын тэмдгийн тухай*. Д.Нацагдоржийн уламжлал утга зохиолын өнөөгийн зангилаа асуудлууд. Улаанбаатар, 73-77 тал. [Otgonbaatar, R. *D.Natsagdorjiin nomyn temdgiin tukhai*. *D.Natsagdorjiin ulamjlal utga zokhiolyn önөөгийн zangilaa asuudluud*. [On the Bookmarks of D.Natsagdorj. In *D.Natsagdorj Tradition and Contemporary Issues in Mongolian Literature*] Ulaanbaatar, pp. 73–77, 1990]
- Отгонбаатар, Р.** (1992). *Халх модон барын монгол ном хэвлэл*. Олон улсын монголч эрдэмтний V их хурал. Улаанбаатар, 54-58 тал. [Otgonbaatar, R. *Khalkh modon baryn mongol nom khevlel*. [Mongolian Woodblock Prints of Khalkh]. In Proceedings of the 5th International Congress of Mongolists. Ulaanbaatar, pp. 54–58, 1992]
- Отгонбаатар, Р.** (1993). *Хутагт найрагчийн хурц уянгын нэгэн*. Mongolica. Vol 4(25). Улаанбаатар, 215-221 тал. [Otgonbaatar, R. *Khutagt nairagchiin khurts uyangyn negen*. [A Sharp Lyric of the Saintly Poet] *Mongolica*, Vol. 4(25). Ulaanbaatar, pp. 215–221, 1993]
- Отгонбаатар, Р.** (1994). *О Биографий Будды, написанной Агваном Доржиевым*. Национальная интеллигенция и духовенство: история и современность, Улан-Удэ., 118-119 стр. [Otgonbaatar, R. *On the Biography of Buddha Written by Agvan Dorzhiev*. In *National Intelligentsia and Clergy: History and Modernity*. Ulan-Ude, pp. 118–119, 1994]
- Отгонбаатар, Р.** (1995). *Один из гарчаков Д.Галсажамбы*. Средневековая культура центральной Азии: письменные источники. Улан-Удэ., 28-33 стр. [Otgonbaatar, R. *One of the Works of D. Galsajamba*. In *Medieval Culture of Central Asia: Written Sources*. Ulan-Ude, pp. 28–33, 1995]
- Отгонбаатар, Р. Цендина, А.Д.** (2011). *Мэгзэмийн холбоотой монголчуудын бүтээсэн хоёр жижиг зохиолын тухай*. Лам нарын сэтгүүл. II боть. Улаанбаатар. [Otgonbaatar, R. & Tsendina, A.D. *Megzemiin kholbootoi mongolchuudyn büteesen khoyor jijig zokhiolyn tukhai*. [On Two Small Works Created by Mongols Related to Mantras]. *Journal of the Lamas*, Vol. II. Ulaanbaatar, 2011]
- Отгонбаатар, Р.** (2013). *Заяын хүрээний бар хэвлэлээс*. Төвд судлал. №2. F.11. Улаанбаатар, 162-169 тал. [Otgonbaatar, R. *Zayiin khüreenii bar khevlelees*. [From the Woodblock Prints of Zaya Monastery]. *Tibetan Studies*, №2. Ulaanbaatar, pp. 162–169, 2013]
- Отгонбаатар, Р.** (2013). *Хачин гайхамшигт дурсгал Хар хотоос илэрлээ*. Шинжлэх ухаан амьдрал. №1. Улаанбаатар, 41-44 тал. [Otgonbaatar, R. *Khachin gaikhamshigt dursgal Khar khotoos ilerlee*. [A Remarkable Discovery from Kharkhot. *Science and Life*, №1. Ulaanbaatar, pp. 41–44, 2013]
- Отгонбаатар, Р.** (2013). *Монголоор сударчилж хэвлэсэн дөрвөлжин үсгийн Субашидын шинэ хуудас*. Шинжлэх ухаан академийн мэдээ. №3(207). Улаанбаатар, 29-36 тал. [Otgonbaatar, R. *Mongoloor sudarchilj khevlesen дөрвөлжин үсгийн Subashidyn shine khuudas*. [A New Page of the Subashid in Square Script Printed in Mongolian] *Proceedings of the Academy of Sciences*, No. 3(207), Ulaanbaatar, pp. 29–36, 2013]
- Отгонбаатар, Р.** (2015). *Чоймзод ламын хийдийн модон барын тойм*. Төвд судлал. №4. Улаанбаатар, 144-175 тал. [Otgonbaatar, R. *Choimzod lamyn khiidiin modon baryn*

- toim. [Overview of the Woodblock Prints of Choimzod Lama Monastery. Tibetan Studies, №4. Ulaanbaatar, pp. 144–175, 2015]*
- Отгонбаатар, Р.** (2014). *Судрын санг эрхлэгч сүүл үеийн гурван өтгөс. “Монголын шинжлэх ухаан, соёлд лам нарын гүйцэтгэсэн үүрэг” эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. Лавайн эгшиг. Улаанбаатар, 56-61 тал. [Otgonbaatar, R. Sudryn sang erkhelegch süül üyiin gурvan ötgös. [Three Late Generation Old Custodians of the Scripture Collection] In The Role of Monks in Mongolian Science and Culture. Conference Proceedings. Lavain Egshig. Ulaanbaatar, pp. 56–61, 2014]*
- Отгонбаатар, Р.** (2016). *Сайн ноён хан аймгийн Хошуу хүрээний бар хэвлэлийн тойм. Төвд судлал №5. Улаанбаатар, 42-66 тал. [Otgonbaatar, R. Sain noyon khan aimgiin Khoshuu khüreenii бар khevleliin toim. [Overview of the Woodblock Prints of Khoshuu Khuree Monastery in Sain Noyon Khan Province] Tibetan Studies, №5. Ulaanbaatar, pp. 42–66, 2016]*
- Отгонбаатар, Р.** (2017). *Ганжуурын зарим боть номыг монгол хүний хураангуйлсан жишээ. “Монгол Ганжуур” олон улсын судалгаа. Улаанбаатар, 215-223 тал. [Otgonbaatar, R. Ganjuuryн зарим boti номыг mongol khüinii khuraanguilsan jishee. [Examples of Certain Volumes of the Kanjur Summarized by the Mongolian Persons] In International Research on the Mongolian Kanjur. Ulaanbaatar, pp. 215–223, 2017]*
- Отгонбаатар, Р.** (2017). *Буриадын Эгэтийн дацангийн төвд бар хэвлэлийн тойм. Төвд судлал. №6. Paper 5. Улаанбаатар, 86-104 тал. [Otgonbaatar, R. Buriadyн Egetiin datsangiin tövöd бар khevleliin toim. [Overview of the Tibetan Woodblock Prints of Eget Monastery in Buryatia] Tibetan Studies, №6. Paper 5, Ulaanbaatar, pp. 86–104, 2017]*
- Отгонбаатар, Р.** (2017). *Эрдэнэпэл хамбын эрдэм номын үйлс. Чин бишрэлт, хамба Эрдэнэпэлийн мэндэлсний 130 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. Улаанбаатар, [Otgonbaatar, R. Erdenepel kхамбын erdem номын үйлс. [The Scholarly Works of Khamba Erdenepel] In Conference Proceedings Dedicated to the 130th Anniversary of Khamba Erdenepel. Ulaanbaatar, 2017]*
- Отгонбаатар, Р.** (2018). *Ламын гэгээний хийдийн бар хэвлэлийн тойм. Төвд судлал №7. Paper 3. Улаанбаатар, 44-91 тал. [Otgonbaatar, R. Lamын gegeenii khiidiin бар khevleliin toim. [Overview of the Woodblock Prints of Lamын Gegeen Monastery] Tibetan Studies, №7. Paper 3, Ulaanbaatar, pp. 44–91, 2018]*
- Отгонбаатар, Р.** (2019). *Багшийн зарим шүлэг зохиолоо бичсэн тухайд. Академич Ц.Дамдинсүрэнгийн мэндэлсний 110 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. Улаанбаатар, 288-292 тал. [Otgonbaatar, R. Bagshiin зарим shüleg zokhioloo bichsen tukhaid. [On Some Poems Written by the Teacher] In Proceedings Dedicated to the 110th Anniversary of Academician Ts. Damdinsuren. Ulaanbaatar, pp. 288–292, 2019]*
- Отгонбаатар, Р.** (2019). *Равжаагийн монгол төвд хэлээр бичсэн хошоод шүлгийн тухай. Төвд судлал №8. Paper 3. Улаанбаатар, 28-38 тал. [Otgonbaatar, R. Ravjaagiin mongol tövöd kheleer bichsen khoshood shüлgiin tukhai. [On Two Poems by Ravjaa Written in Mongolian-Tibetan Languages] Tibetan Studies, №8. Paper 3, Ulaabaatar, pp. 28–38, 2019]*
- Отгонбаатар, Р.** (2020). *Зурагт монгол судрын эртний хэвлэлийн хэсэг. Шинжлэх ухаан амьдрал сэтгүүл. №1(356). Улаанбаатар, 14-19 тал. [Otgonbaatar, R. Zuragt mongol sudryn ertний khevleliin kheseg. [Fragments of Ancient Illustrated Mongolian Scriptures. Science and Life, №1, Ulaanbaatar, pp. 14–19, 2020]*
- Отгонбаатар, Р.** (2020). *Хутагт ламын хийдийн бар хэвлэлийн тоймоос. Төвд судлал. №9. Улаанбаатар, 25-36 тал. [Otgonbaatar, R. Khutagt lamын khiidiin бар khevleliin тоимоос. [Overview of the Woodblock Prints of Khutagt Lama Monastery] Tibetan Studies, №9. Ulaanbaatar, pp. 25–36, 2020]*

- Отгонбаатар, Р.** (2020). *Эртний модон барын монгол номын хоёр дурсгал*. Шинжлэх ухаан амьдрал сэтгүүл. №4(359) Улаанбаатар, 19-25 тал. [Otgonbaatar, R. *Ertnii zuragt modon baryn mongol nomryn khoiyor dursgal*. [Two Ancient Mongolian Woodblock-Printed Book Monuments. Science and Life, №4(359). Ulaanbaatar, pp. 19-25, 2020]
- Отгонбаатар, Р.** (2020). *Данзан-Осор гуайтай цөөн уулзсанаа далимдуулж хэлхсэн хэдэн үг*. Эрдэмт лам Данзан-Осор гуайн мэндэлсний 130 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. Улаанбаатар, 105-110 тал. [Otgonbaatar, R. *Danzan-Osor guiatai uulzsanaa dalimduulj khelkhsen kheden üg*. [Words Shared on Meetings with Danzan-Osor Lama. In *Proceedings Dedicated to the 130th Anniversary of Lama Danzan-Osor*. Ulaanbaatar, pp. 105-110, 2020]
- Отгонбаатар, Р.** (2020). *Найман гэгээн номын нэн эртний хэвлэл*. Шинжлэх ухаан амьдрал сэтгүүл №3(358). Улаанбаатар, 30-33 тал. [Otgonbaatar, R. *Naiman gegeen nomyn nen ertnii khevlel*. Most Ancient Edition of the Eight Saints' Scriptures. Science and Life, №3(358). Ulaanbaatar, pp. 30-33, 2020]
- Отгонбаатар, Р.** (2024). *Мэдэгдэхүүнийг бэлгэтээ гийгүүлэгчийн монгол хэвлэл*. Шинжлэх ухаан амьдрал сэтгүүл. №2(373). Улаанбаатар, 52-58 тал. [Otgonbaatar, R. *Medegdekhüüniig belgeteye giigüülegchiin mongol khevlel*. [Mongolian Edition of "Symbolic Enlightener of Knowledge". Science and Life, №1(373). Ulaanbaatar, pp. 52-58, 2024]
- Отгонбаатар, Р.** (2025). *Зэс барын Доржжодов*. Шинжлэх ухаан амьдрал сэтгүүл. №1 (376). Улаанбаатар, 37-41 тал. [Otgonbaatar, R. *Zes baryn Dorjjodov*. [Dorjjodov Printed on the Copper Printing Blocks. Science and Life, №1(376). Ulaanbaatar, pp. 37-41, 2025]
- Отгонбаатар, Р.** (2021). *Хувь хүний бүтээсэн модон барын номын хэвүүд хийгээд нэгэн төвөд барын гарчиг*. Төвөд судлал. №10. Улаанбаатар, 86-97 тал. [Otgonbaatar, R. *Khuvii khüunii бүтэсэн modon baryn nomyn khevүүд khiigeed negen tövöd baryn garchig*. [Woodblock Prints Created by Individuals and a Catalog of Tibetan Titles. Tibetan Studies, №10. Ulaanbaatar, pp. 86–97, 2021]
- Отгонбаатар, Р.** (2021). *Шагж гуайн бүтээл Сахиусан Дара эх*. Монгол хэл зохиол судлал, судлалын хөгжил, чиг хандлага. Олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. Улаанбаатар, 423-428 тал. [Otgonbaatar, R. *Shagj guain бүтээл Sakhiusan Dara eke*. ["Angelic Tara" Created by Shagj. In *Proceedings of the International Conference on Mongolian Literature and Linguistics Studies and Their Development Trends*. Ulaanbaatar, pp. 423–428, 2021]
- Отгонбаатар, Р.** (2022). *Бээжингийн уламжлалт хэвлэлийн нэгэн бичмэл гарчиг*. Төвөд судлал. №11. Улаанбаатар, 140-149 тал. [Otgonbaatar, R. *Beejngiin ulamjлalt khevleliin negen bichmel garchig*. [A Manuscript Title of Traditional Beijing Printing. Tibetan Studies, №11. Ulaanbaatar, pp. 140–149, 2022]
- Отгонбаатар, Р.** (2023). *Х.Гаадан багшийн төвөд хэл бичих заасан онцлогоос*. "Хархүүгийн Гаадан-100: Түүх, соёл, шашин" эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. Улаанбаатар, 116-122 тал. [Otgonbaatar, R. *Kh.Gaadan bagshiiin tövöd khel bichig zaasan ontslogoos*. [On Teacher Kh.Gaadan's Methods of Teaching Tibetan Writing. In *Conference Proceedings "Kharkhuu's Gaadan-100: History, Culture, Religion"*. Ulaanbaatar, pp. 116–122, 2023]
- Отгонбаатар, Р.** (2024). *Сайчунгагийн гарын тэмдгийн тухай*. "Монгол туургатны уран зохиол, соёлын өв, уламжлал, шинэчлэл: На.Сайчунга". На.Сайчунга-110. Олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. Улаанбаатар, 101-104 тал. [Otgonbaatar, R. *Saichungaagiin garyn temdgiin tukhai*. On the Seal Used by Saichunga. In *Proceedings of the International Conference "Heritage, Tradition and*

Innovation of Literature and Culture of Mongolian Nationalities: Na. Saichunga”. Na. Saintsogt-110. Ulaanbaatar, pp. 101–104, 2024]

Отгонбаатар, Р. (2024). *Сайчунга зохиолчийн өвөрмөц сонирхолтой шүлгийн өвөөс*. “Монгол туургатны уран зохиол, соёлын өв, уламжлал, шинэчлэл: На.Сайчунга”. На.Сайнцогт-110. Олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. Улаанбаатар, 154-161 тал. [Otgonbaatar, R. *Saichunga zokhiolchiin övörmöts sonirkholtoi shülgiin övөөс*. [From the Unique Poetry Legacy of Saichunga. In Proceedings of the International Conference “Heritage, Tradition and Innovation of Literature and Culture of Mongolian Nationalities: Na. Saichunga”. Na. Saintsogt-110”. Ulaanbaatar, pp. 154–161, 2024]

Отгонбаатар, Р. (2024). *Бурхан багшийн намтарт холбогдох үйснээ бичсэн шүлгийн эхлэл (Хан хөвүүнийг хайгуулдсан шүлгийн эхэн хэсэг)*. Mongolica. An international journal of Mongol studies Vol 55, Улаанбаатар, 142-146 тал. [Otgonbaatar, R. *Burkhan bagshiin namtart kholbogdokh üisnee bichsen shülgiin ekhlel (Khan khövüüniig khaiguuldsan shülgiin ekhen kheseg)*. [Opening Verses of Poem Represented on the Birch Bark and Related to Buddha’s Biography. (Poem beginning search for the Prince) Mongolica: An International Journal of Mongol Studies, Vol. 55. Ulaanbaatar, pp. 142–146, 2024]

Отгонбаатар, Р. (2024). *Ноён хутагтын зохиолын нэг үгийг зөв буулгах тухайд*. Ноён хутагтын өв: өнгөрсөн одоо ирээдүй. Говийн ноён хутагт Данзанравжаагийн мэлмий гийсний 220 жилийн ойд зориулсан “Ноён хутагтын өв, өнгөрсөн, одоо, ирээдүй” олон улсын эрдэм шинжилгээний VI хурлын илтгэлүүдийн эмхэтгэл. Улаанбаатар, 77-83 тал. [Otgonbaatar, R. *Noyon khutagtyn zokhiolyn neg ügiig zöv buulgakh tukhaid*. On Correct Translitterating of One Word in the Works of Noyon Khutagt. In Proceedings of the 6th International Conference “Noyon Khutagt’s Legacy: Past, Present, Future”, dedicated to the 220 anniversary of Gobi King Reincarnate Danzanravjaa. Ulaanbaatar, pp. 77–83. 2024]



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial. See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>